



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/100

Алтай хот

Сар шинийн баярт зориулсан  
үндэсний бөхийн барилдаанд зардал  
гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Билгийн тооллын 17 дугаар жарны "Үзэсгэлэн болгогч" хэмээх усан туулай жилийн Цагаан сарын баярт зориулсан үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулж, зарцуулагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2.Барилдаанд шаардагдах 3,045,000 (гурван сая дөчин таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20...<sup>25</sup> оны ...<sup>02</sup>  
 дугаар сарын ...<sup>16</sup>...-ны өдрийн ...<sup>1100</sup> дугаар  
 захирамжийн хавсралт

**ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Даваа	Бөхийн тоо	Нэг бөхийн шагнал	Нийт
1	1 давсан	8	40,000	320,000
2	2 давсан	4	100,000	400,000
3	Шөвгөрсөн	2	250,000	500,000
4	Үзүүрлэсэн	1	500,000	500,000
5	Түрүүлсэн	1	800,000	800,000
6	Нийт			2,520,000

**Бусад зардал**

№	Үүрэг гүйцэтгэсэн	Ажилласан хүний тоо	Нэг хүнд олгох ажлын хөлс	Нийт
1	Гарын даа	1	30,000	30,000
2	Хөлийн цэц	1	30,000	30,000
3	Засуул	4	30,000	120,000
4	Эмч	1	30,000	30,000
5	Тайлбарлагч	1	30,000	30,000
6	Медаль	4 ш	8,000	32,000
7	Өргөмжлөл	4 ш	12,000	48,000
8	Тавгийн идээ	35 ш (ул боов)	3,000	105,000
9		Ааруул, чихэр	100,000	100,000
	Дүн			525,000
	Нийт дүн			3,045,000

\_\_оОо\_\_